



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЯАМ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2022 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 он

Эрчим хүчний яамны Дотоод аудитын хорооноос баталсан 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 9, төлөвлөгөөт бус 3, нийт 12 дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1.1 Төлөвлөгөөт ажил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны баталсан төлөвлөгөөний дагуу 9 дотоод аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- I. Эрчим хүчний сайдын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/46 тоот тушаалаар баталсан “Шилэн дансны аудитыг хийж гүйцэтгэх удирдамж”-ийн дагуу салбарын бүх байгуулагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар дотоод аудит хийж, 5 зөвлөмжийг гаргасан.
- II. Сайдын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/57 тоот тушаалаар баталсан “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэлийн төсөл”-ийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитаар илэрсэн 3 асуудалд 4 зөвлөмж боловсруулсан. Тайланг Дотоод аудитын хорооны 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцэж, дотоод аудитын дүн, зөвлөмжийг 22/04 тогтоолоор, зөвлөмж хэрэгжүүлэхийг 22/05 дугаар тогтоолоор баталгаажуулав.
- III. Эрчим хүчний Сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/79 тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, эдийн засгийн төлөвлөлт, гүйцэтгэл, хүний нөөц, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт, санхүүгийн дотоод хяналтын хэрэгжилтэд дотоод аудит хийж гүйцэтгэсэн.
- IV. Эрчим хүчний Сайдын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/90 тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2021 он, 2022 оны эхний 4 сарын байдлаар санхүүгийн үйл ажиллагаа, эдийн засгийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт, санхүүгийн дотоод хяналтын хэрэгжилтэд дотоод аудит хийж гүйцэтгэв.
- V. Сайдын 2022.08.25-ны өдрийн А/168 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу 2022 оны 7 сарын байдлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудитыг хийж гүйцэтгэв. Салбарын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 97.3% үнэлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах, дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг ханган 2022.12.15-ны байдлаар тайлагнах үүрэг даалгаврыг ТНБД-ын 2022.09.30-ны өдрийн в/3748 тоот албан бичгээр 37 байгууллагад хүргүүлэв.
- VI. Сайдын баталсан 2022.10.03-ны өдрийн удирдамжийн дагуу “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгэсэн. Аудитаар 10 асуудал илрүүлэн, 13 зөвлөмж боловсруулсан. Аудитын дүнг Сайдад танилцуулсан.
- VII. Сайдын 2022.11.28-ны өдрийн А/246 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу Эрчим хүчний сайдын 2022 оны багцын урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод аудитыг гүйцэтгэсэн. Дотоод аудитын дүнг удирдлагуудад танилцуулж 2023.01.12-ны өдрийн 04, 05 тоот дотоод албан бичгээр зөвлөмжийг ТЗУГ, СХОГ-т тус тус хүргүүлэв.
- VIII. Сайдын 2022.09.29-ны өдрийн удирдамжийн дагуу “Даланзадгадын ДЦС” ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүү, эдийн засаг, худалдан авах ажиллагаа, хөрөнгө

оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэл, хүний нөөцийн бодлого, санхүүгийн дотоод хяналтын 2021 он, 2022 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтэд шалгалт хийж гүйцэтгэв.

- IX. Сайдын 2022.09.29-ны өдрийн удирдамжийн дагуу “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүү, эдийн засаг, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэл, хүний нөөцийн бодлого, санхүүгийн дотоод хяналтын 2021 он, 2022 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтэд шалгалт хийж гүйцэтгэв.

1.2 Төлөвлөгөөт бус аудит

Төлөвлөгөөт бус 3 ажил хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Эрчим хүчний сайдын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулагдсан “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагын үйл ажиллагаанд шалгалтын ажлыг хийж гүйцэтгэв. Шалгалтаар 4 үл нийцэлд 3 зөвлөмж өгч ажиллав.
2. Сайдын 2022.08.18-ны өдрийн А/163 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй “Эрчим хүчний төсөл-2”-ын үйл ажиллагаанд шалгалт хийж гүйцэтгэв.
3. Сайдын баталсан 2022.10.03-ны өдрийн удирдамжийн дагуу “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-д холбогдох өргөдөл гомдлын хүрээнд шалгалт хийж гүйцэтгэв.

Дотоод аудит, шалгалтанд хамрагдсан компаниудын хувьд давхардсан тоогоор 58 асуудал илэрсэн бөгөөд алдааг дахин гаргахгүй, цаашид анхаарч ажиллах талаар 76 зөвлөмжийг хүрүүлсэн. Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг Дотоод аудитын хорооны тогтоол болон тайлангийн хамт албан бичгээр хүргүүлж ажиллав. Зөвлөмжийн биелэлтийг эргэж хянах хуудас хөтөлж байна.

1.3 Салбарын үйлдвэр компаниудад илэрсэн асуудлууд

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК, Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК, Эрчим хүчний төсөл-2, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэлийн төсөл”-ийн нэгж, төрийн өмчит компанид хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлүүдийг багцалж авч үзвэл:

Асуудал:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй.

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тооцоо судалгаа муу, үндэслэлгүй хийснээс шалтгаалан нэн тэргүүнд хийгдэх ёстой ажлууд орхигдох, шаардлагагүй хөрөнгө оруулалт, их засварын ажлууд төлөвлөгдөж, олон дахин тодотгол хийх зэргээр хугацаа алдах эрсдэлтэй.

2. Захиалагч бүх тендерээс татгалзах явцад хуулийн 30 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг баримтлалгүй 3-9 удаа тендер зарласан байгаа нь бараа, ажил үйлчилгээний нийлүүлэлтийг удаашруулах, компанийн засвар үйлчилгээний ажил хугацаандаа хэрэгжих боломжгүй болох нөхцөл байдалд хүргэсэн байна.
3. Бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийг задалж, шууд худалдан авалтыг зохион байгуулсан.
4. Үнэлгээний хороо нь хуулийн 47.2 дахь хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагааны журмыг сонгох, тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийн урилгыг зарлах, тендер хүлээж авах, нээх, тендерийн үнэлгээ хийх, гэрээ байгуулахад захиалагчид арга зүйн туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Тендерийн баримт бичиг боловсруулалт хангалтгүй.
5. Тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбоотойгоор Сангийн яаманд гомдол гарч байгаа нь үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ зохих хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаагүйтэй холбоотой байна. Тендерт оролцогчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байхад дууссан гэж үнэлгээг буруу хийсэн.

Шалгуур:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 5.5 “энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл НТШ-ын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”

Асуудал:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-ын дагуу бүртгэл хөтлөх, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байна. Төслийн гүйцэтгэгчээс компанид хүлээлгэн өгсөн дагалдах сэлбэг материалын бүртгээгүй, зарцуулалтад тавих хяналт сул байна.
2. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт оновчгүй байгаагаас үүдэн орон тооны давхардал гаргаж, цалингийн үргүй зардал гарсан.
3. Техникийн нөхцөл олголтын орлогыг аккруэл сууриар бүртгээгүй, техникийн нөхцөл олголтод тавих хяналт хангалтгүй байна.
4. Төслийн гүйцэтгэгч төслийн тоног төхөөрөмжүүдэд эвдрэл гарч, гэмтэл устгах ажлыг компанийн ажилчдаар гүйцэтгүүлэн, ажлын хөлсийг компанийн дансанд төвлөрүүлэлгүй, ажилчдын гарт олгосон байна. /Тухайн ажилчид компаниас сарын цалин олгогдсон байгаа./
5. 2021 оны орлого зардлын гүйцэтгэлийн тайланг зөвхөн төлөвлөгөө, гүйцэтгэлээр гаргаж, харьцуулалт, дүн шинжилгээ хийж байгаа нь үр дүнгүй. Үйлдвэрлэлтийн өсөлттэй уялдуулж хувьсах зардлын өсөлтийг тооцсон гүйцэтгэлд ногдох төлөвлөлтийг хийгээгүй.

6. Өр авлагыг цаг тухайд нь тооцоо нийлж актаар баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгах ажил хангалтгүй.
7. Гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй, алданги тооцоогүй.
8. Дотоод хяналтын хэлтсийн аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Шалгуур:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-т “Аж ахуйн нэгж байгууллага санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө.”
- Мөн хуулийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.” Үүнд:
 - ✓ 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”
 - ✓ 5.1.4-т “үнэн зөв байх”
 - ✓ 5.1.6-д зохицох зарчим
 - ✓ 6.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.”
 - ✓ 13.1-т “ Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно”,
- СТОУС-15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлогын бүртгэлийн стандарт
- НББОУССтандарт “Орлого зарлага зохицох зарчим”,

Асуудал:

1. Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагаа хангалтгүй. Тушаалын биелэлтэд тавих хяналт хангалтгүй.
2. Байгууллагын захирамжлалын баримт бичиг болох зарим тушаалын үндэслэл буруу тодорхойлогдсон, хууль тогтоомж, эрх зүйн актад нийцээгүй, үг үсэг, утгын алдаатай, /баримт, тооцооллоор нотлогдохгүй/.
3. Ур чадварын нэмэгдэл олголтод шударга, ил тод зарчим алдагдсан, нэмэгдэл олгох хувь харилцан адилгүй, хувь тогтооход баримтлах журам байхгүй, удирдлага өөрийн үзэмжээр шийддэг нь ажиллагсдын дунд ойлгомжгүй, сэтгэл дундуур үлдэх нөхцөл байдал үүсгэсэн.
4. “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Шинээр ажилтан шалгаруулж авах журам”-ыг мөрдөж ажилладаггүй, хүний нөөцийн бодлого төлөвлөлт алдагдсан. Хүний нөөцийн нөхөн дүүргэлт дутуу, шилжилт хөдөлгөөн ихтэй байгаа нь эрчим хүчний салбарын найдвартай, жигд ажиллагааг хангахад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан орон тоог хэтрүүлэн ажилласан, бүтцийн схемд ороогүй шинэ ажлын байр бий болгосон.
6. Албан бичиг хэрэг хөтлөлт, бичиг үсгийн алдаа, тушаал шийдвэрийн дугаарлалт, дараалал, хууль зүйн үндэслэл, дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлт, гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул, боловсон хүчний мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, сургах үйл ажиллагаа дутмаг, бичиг баримтын бүрдэл, хадгалалт, хамгаалалтын стандарт зөрчигдсөн.
7. “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж авах, ажлын байранд шилжүүлэн ажиллуулах журам”-ын 5.1.2-т заасан “Сонгон шалгаруулалтын материалын сан”-г бүрдүүлж ажиллаагүй.

8. Ажилтан албан хаагчдыг шинээр ажилд томилохдоо компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг мөрдөж ажиллаагүй

Шалгуур:

- Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 5.7.1. Байгууллагаас боловсруулан гаргаж буй баримт бичиг нь хууль тогтоомж, эрх зүйн актад нийцсэн, стандартын шаардлага хангасан, найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй байна.
- 5.7.3.1. Ажилтан баримт бичгийн төсөлд тусгагдсан судалгаа, мэдээ, мэдээлэл, тоо баримтын үнэн зөвийг биечлэн хариуцах үүрэг хүлээнэ.
- 5.7.8. Баримт бичгийн төсөл нь боловсруулалтын шаардлага хангаагүй, утга агуулга, хэл найруулга, зөв бичих дүрмийн алдаатай бол боловсруулсан, хянасан ажилтан хариуцлага хүлээнэ.
- 5.8.3. Баримт бичиг нь стандартын шаардлага хангаагүй, утга агуулга, хэл найруулга, зөв бичих дүрмийн алдаатай бол энэ талаар тэмдэглэж, ажилтанд буцааж, дахин боловсруулалт хийлгэнэ.
- 6.3.5.6. хяналтад авсан удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийн явц, биелэлтийн мэдээг тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан улирал, хагас жил, бүтэн жилээр гаргаж, байгууллагын удирдлагад танилцуулна.
- Хөдөлмөрийн дотоод журам
- Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргүүд

ДОТООД АУДИТЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ буюу төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	Төрийн өмчит хувьцаат компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх: <ul style="list-style-type: none"> - “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, - “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК, - “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэлийн төсөл” - “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК - Сайдын багцын 2022 оны урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл - Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК - “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК 	биелсэн	100%
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд: <ul style="list-style-type: none"> - 2021 оны жилийн эцсийн байдлаар /2022.01.31/ - 2022 оны эхний хагас жилийн байдлаар /2022.07.30/ 	биелсэн	100%
Төлөвлөгөөт бус ажил:			
3	<ul style="list-style-type: none"> - Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагын үйл ажиллагаанд шалгалт хийх - “Эрчим хүчний төсөл-2” - “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК ҮЭХ-ны асуудлаар 	биелсэн	100%

Дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсан 2022 оны ажлыг 100% хийж гүйцэтгэсэн.

---oOo---